**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН: “ТАЛСТ ДИСКОВЕРИ” ХХК**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТАЛСТ ДИСКОВЕРИ” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ХӨТӨЛ-УЛААН ‘’ ЛИТИЙН РУБИДЫН ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**/Регистрийн дугаар: 5872006/**





**УЛААНБААТАР ХОТ**

**2026 ОН**

# “ТАЛСТ ДИСКОВЕРИ” ХХК

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ТАЛСТ ДИСКОВЕРИ” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ХӨТӨЛ-УЛААН ‘’ ЛИТИЙН РУБИДЫН ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015077

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 5872006

**Төлөвлөгөөтэй танилцсан:**

**“ТАЛСТ ДИСКОВЕРИ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Б.САРАНТУЯА**

УЛААНБААТАР ХОТ
ДИСКОВЕРИ
ХХК
ШТМ3965 9023080784
5872006

**Төлөвлөгөө боловсруулсан:**

**“ТАЛСТ ДИСКОВЕРИ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРЭГЖИЛТЭН**

**Б.ХОНГОРЗУЛ**

**УЛААНБААТАР ХОТ**

**2026 ОН**

# ГАРЧИГ


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 3

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 14

2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга ........ 14

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 16

3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ........ 16

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ........ 20

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 21

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 24

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 25

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 26

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 26

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 27

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 31

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ........ 34

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 36

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ37

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

*Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд* ..........3
*Хүснэгт 2. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт* ..........5
*Хүснэгт 3. Ашиглалтын технологийн үндсэн элементүүдийн параметрүүд* ..........6
*Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим* ..........7
*Хүснэгт 5. Уурхайн 2026 оны үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ* ..........7
*Хүснэгт 6. Ил уурхайд ажиллах үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд* ..........7
*Хүснэгт 7. Өрөмдлөгийн ажил* ..........8
*Хүснэгт 8. Өрмийн машины бүтээл* ..........8
*Хүснэгт 9. Тоног төхөөрөмжийн хувилбаруудын харьцуулалт* ..........8
*Хүснэгт 10. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл* ..........16
*Хүснэгт 11. 2026 онд хэрэгжүүлэх  Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал* ..........20
*Хүснэгт 12. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ* ..........21
*Хүснэгт 13. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө* ..........24
*Хүснэгт 14. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө* ..........25
*Хүснэгт 15. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө* ..........26
*Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө* ..........27
*Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр* ..........34
*Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө* ..........37
*Хүснэгт 19. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө* ..........38

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

*Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг* ..........4
Зураг 2. Гадаад тээврийн замын маршрут ..........11
*Зураг 3. Засварын газрын схем зураг* ..........13

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хөтөл-Улаан” нэртэй хайлуур литийн рубидийн ордыг ил далд аргаар ашиглах төсөл
**Төслийн зорилго:** Хөтөл улаан хайлуур жоншны илрэлийн урд талд Хөхдэл улааны ховор металлын хүдэржилттэй (Be, Sn, Li) пегматитын 5 биет тогтоосон байна. Хөтөл улаан лити, рубидийн орд нь Төв монголын атираат муж, Идэрмэг бүсэд хамаарагдана. Төслийн үндсэн түүхий эд нь дээр дурдсан Хөтөл улааны лити-рубидийн орд бөгөөд энэ ордыг түшиглэн лити баяжуулах үйлдвэр байгуулахаар төлөвлөөд байна.

**Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.** Дотоодын “Талст дисковери” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011854786, регистрийн дугаар: 5872006.

**Тусгай зөвшөөрөл:** “Хөтөл Улаан” нэртэй 2659X дугаартай 354.67 га талбай бүхий хайгуулын тусгай зөвшөөрлийг 2000 оны 10-р сарын 16-ны өдрийн АМГ-ын ГУУКА-н даргын шийдвэрээр “Си Ар Эм Ай” ХХК-д олгосон байна. Улмаар АМГТХЭГ-н ГУУКА-н даргын шийдвэрээр 2009 оны 08-р сарын 20 өдөр MV-015077 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан байдаг. Тус ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2015 оны 01-р сарын 08 өдрийн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 11 тоот шийдвэрээр “Дүншинхэние” ХХК-д шилжүүлсэн байна. Харин 2023 оны 08-р сарын 29-ний өдөр “Талст Дисковери” ХХК-д шилжсэн байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 364.57 га талбайг хамарч байна.
**Төслийн байршил**
“Хөтөл-Улаан” ашиглалтын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байр зүйн L49-62 хавтгайн хэмжээнд Улаанбаатар хотоос баруун урд зүгт 280 км зайд, Даланжаргалан сумаас баруун хойд зүгт 25 км зайд, төмөр замын 25-р зөрлөгөөс баруун хойш 12 км зайд байрлана.

***Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд***

| № | Тусгай зөвшөөрлийн дугаар | Талбайн хэмжээ, га | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | MV-015077 | 364.67 | 108° | 50' | 31.62” | 46° | 00' | 1.65” |
| 2 | | | 108° | 49' | 11.62” | 46° | 00' | 1.65” |
| 3 | | | 108° | 48' | 51.61” | 46° | 00' | 41.65” |
| 4 | | | 108° | 48' | 51.61” | 46° | 00' | 51.66” |
| 5 | | | 108° | 49' | 17.62” | 46° | 00' | 51.66” |
| 6 | | | 108° | 49' | 17.62” | 46° | 01' | 1.65” |




*Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг*

Ордын геологийн тогтоцХөтөл улаан талбай, түүний орчимд өмнөх судлаачдын геологийн ажлын тайлан материалд боловсруулалт хийж, тектоник-структур формацын орчин үеийн ангилал зүйд нийцүүлэн дүүргийн геологийн хөгжлийн түүхийг ерөнхийлөн тусгасан болно. Хөтөл улааны орд нь Төв монголын атираат муж, Идэрмэг бүсэд хамаарагдана. Геологийн тогтоц давхарга зүйн ангиллын хувьд нийлмэл бөгөөд үүсэн бүрэлдсэн цаг хугацаа, орон зайн томоохон хэлбэлзэлтэй. Талбайн баруун болон хойд хэсэг, мөн зүүн урд, баруун урд хэсэгт толгодын орой хэсгээр палеозойн дээд триас-доод юра Дархан формацын настай риолит, риодацит, трахириолит болон риолитийн туф зэрэг бялхмал хүчиллэг, дундлаг найрлагатай галт уулын чулуулгууд тархсан байдаг. Дархан формацын риолит, риодацит, трахириолит талбайн урд, зүүн урд, төвийн хэсэгт багахан, баруун урд, баруун, хойд хэсэгт нилээд өргөн тархалттай. Суваг малталт, цооногуудын үр дүнгээс харахад пегматитын судал бүхий хүдрийн биетүүд нь тектоник хагарал, суларсан эвдрэлийн бүсүүдэд кварцжих, серицитжих, цахиуржих зэрэг гидротермаль хувирлуудыг даган үүсжээ. Хүдрийн биетүүд нь зонхилон зүүн хойд зүгт сунасан, зүүн урагш чигт 40-85°-аар унасан байх ба хагарал, дэл судлын чулуулгаас хэрчигдэж олон тооны блоклог тогтоцтой пегматитын судлын биет хэлбэрээр хөгжсөн байна. Хүдрийн биетүүд нь гадаргууд хадан арш бараг үүсгэдэггүй, дөрөвдөгчийн сэвсгэр хурдас болон эллюви, деллювийн үйрмэг эмхдэсээр хучигдсан байдаг.

Төв ба зүүн хэсэг нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд хэсэгт байх ба 800м урт, 400м өргөнтэй талбайд ховор металлын хүдэржилттэй пегматитын судлууд тогтоогдсон. Судалгаагаар хүдрийн 5 биет тогтоогдсон бөгөөд кварц-лепидолит- ортоклазтай пегматит төрлийн хүдэржилт зонхилох бөгөөд хүдрийн биет нь зүүн хойш чигтэй, зүүн урагш зүгт 40- 70 градусын уналтай байна.

Хүдрийн I биет нь талбайн урд хэсэгт байрлах ба тус ордын голлох том 2 хүдрийн биетийн нэг нь билээ. Хүдрийн I биет БХ350° азимуттай, 15-35 м өргөн риолитын судлаар төв, зүүн хэсэгт хуваагддаг.

Хүдрийн II биет нь байрлалын хувьд хүдрийн I биетийн хойд талд байрлах бөгөөд

БХ350° азимуттай, 15-35 м өргөн риолитын судлаар төв, зүүн хэсэгт хуваагддаг. өв хэсгийн хүдрийн II биет дунджаар 210м орчим урттай, 95м хүртэл гүнд үргэлжилсэн, 1.02-4.3м хүртэл зузаантай, мөн хагарал, тасралт эвдрэл, дэл судлын чулуулгаар хүдрийн биет нь хуваагдан тасарч 6 жижиг биетэд хуваагдсан.

Хүдрийн III биет нь байрлалын хувьд хүдрийн II биетийн баруун талд, хүдрийн V биетийн зүүн талд байрлах бөгөөд дунджаар 46м болон 17м урттай, 5.5-7м хүртэл үргэлжилсэн 2 биет тогтоогдсон бөгөөд зузаан нь 0.92-7.3 м байна.

Хүдрийн IV биет нь байрлалын хувьд баруун хойд талд буюу хүдрийн V биетийн хойд талд байрлана. Хүдрийн IV биет нь 49м урттай, 25.0м хүртэл гүн үргэлжилсэн нэг биет тогтоогдсон бөгөөд зузаан нь 3.5 м байна.

Хүдрийн V биет нь байрлалын хувьд эрлийн 1-р талбайн хамгийн баруун талынх бөгөөд хүдрийн III биетийн баруун талд байрлана. Хүдрийн V биет нь 40м урттай, 31.0м хүртэл гүн үргэлжилсэн 1 биет тогтоогдсон бөгөөд зузаан нь 3.83 м байна.

Ордын нөөц

“Хөтөл Улаан” Лити, Рубидийн ордод “Талст Дисковери” ХХК нь 2023 онд хайгуулын а гүйцэтгэж ЭБМЗ-н 2024 оны 11-р сарын 22-ны ХХ-13-09 тоот дүгнэлт, Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 12-р сарын 26-ны өдрийн Н/79 тоот тушаалаар ордын геологийн нөөцийг боломжтой С зэрэглэлээр 352.6 мян.тн хүдэрт 0.73%-н агуулгатай 2.5 мян.тн Li2O, 0.14%-н дундаж агуулгатай 488.8 тн Rb2O гэж улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн.

***Хүснэгт 2. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт***

| № | Нөөцийн зэрэглэл | Хүдрийн биетийн дугаар | Хүдрийн нөөц | | Дундаж агуулга, % | | Металлын нөөц, тн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эзлэхүүн, $м^3$ | Хүдрийн хэмжээ, тн | $Li_2O$ | $Rb_2O$ | $Li_2O$ | $Rb_2O$ |
| Төвийн биет | | | | | | | | |
| 1 | С-1 | 1c | 18,890.92 | 50,438.76 | 0.74 | 0.14 | 375.64 | 69.36 |
| 2 | С-2 | 1-1c | 10,220.58 | 27,288.94 | 0.71 | 0.14 | 194.16 | 38.16 |
| 3 | С-3 | 1-2c | 1,596.81 | 4,263.49 | 1.03 | 0.20 | 44.05 | 8.50 |
| 4 | С-4 | 1-3c | 850.72 | 2,271.42 | 0.83 | 0.17 | 18.97 | 3.97 |
| 5 | С-5 | 1-4c | 1,745.67 | 4,660.94 | 0.73 | 0.15 | 34.09 | 7.16 |
| 6 | С-6 | 2c | 1,860.92 | 4,968.66 | 0.42 | 0.09 | 20.68 | 4.51 |
| 7 | С-7 | 2ac | 524.33 | 1,399.96 | 0.60 | 0.15 | 8.44 | 2.10 |
| 8 | С-8 | 2bc | 605.83 | 1,617.56 | 0.59 | 0.14 | 9.48 | 2.30 |
| 9 | С-9 | 2-1c | 11,993.69 | 32,023.15 | 0.93 | 0.15 | 297.56 | 49.61 |
| 10 | С-10 | 2-2ac | 1,009.25 | 2,694.70 | 0.52 | 0.11 | 13.89 | 3.08 |
| 11 | С-11 | 2-2bc | 5,987.94 | 15,987.79 | 0.51 | 0.12 | 81.09 | 19.12 |
| 12 | С-12 | 2-2cc | 544.69 | 1,454.32 | 0.58 | 0.11 | 8.44 | 1.63 |
| 13 | С-13 | 3c | 1,435.81 | 3,833.62 | 0.93 | 0.15 | 35.69 | 5.73 |
| 14 | С-14 | 3ac | 55.47 | 148.10 | 0.84 | 0.13 | 1.24 | 0.20 |
| 15 | С-15 | 4c | 5,427.11 | 14,490.38 | 0.83 | 0.14 | 120.73 | 20.10 |
| 16 | С-16 | 5c | 3,969.45 | 10,598.44 | 0.52 | 0.13 | 55.42 | 14.09 |
| **Боломжтой С зэрэглэлээр** | | | **66,719.19** | **178,140.23** | **0.74** | **0.14** | **1,319.57** | **249.62** |
| Зүүн биет | | | | | | | | |
| 17 | С-17 | 1e | 16,481.93 | 44,006.77 | 0.49 | 0.12 | 215.39 | 51.68 |
| 18 | С-18 | 1-1e | 2,249.05 | 6,004.96 | 0.39 | 0.11 | 23.65 | 6.64 |
| 19 | С-19 | 2e | 46,615.20 | 124,462.60 | 0.83 | 0.15 | 1,028.47 | 180.90 |
| **Боломжтой С зэрэглэлээр** | | | **65,346.18** | **174,474.33** | **0.73** | **0.14** | **1,267.51** | **239.22** |
| Ордын хэмжээнд | | | | | | | | |
| **Нийт боломжтой С нөөц** | | | **132,065.38** | **352,614.56** | **0.73** | **0.14** | **2,587.08** | **488.84** |

## УУРХАЙН ОЛБОРЛОЛТ ТООЦОО, ТӨЛӨВЛӨЛТ

Хөтөл улааны орд нь 5 хүдрийн биетээс тогтох ба кварц-лепидолит-ортоклазтай пегматит төрлийн хүдэржилт зонхилох бөгөөд хүдрийн биет нь зүүн хойш чигтэй, зүүн урагш зүгт 40-70 градусын уналтай байна.

Хүдрийн I биет нь БУ-ЗХ60° азимуттай, ЗУ40-80° уналын өнцөгтэй, 220м орчим урттай, 75м хүртэл гүнд үргэлжилсэн, 1.1-5.2м хүртэл зузаантай.

Хүдрийн II биет нь байрлалын хувьд хүдрийн I биетийн хойд талд байрлах бөгөөд БХ350° азимуттай, дунджаар 210м орчим урттай, 95м хүртэл гүнд үргэлжилсэн, 1.02- 4.3м хүртэл зузаантай.

Хүдрийн III биет нь байрлалын хувьд хүдрийн II биетийн баруун талд, хүдрийн V биетийн зүүн талд байрлах бөгөөд дунджаар 46м болон 17м урттай, 5.5-7м хүртэл гүн үргэлжилсэн 2 биет тогтоогдсон бөгөөд зузаан нь 0.92-7.3 м байна.

Хүдрийн IV биет нь байрлалын хувьд баруун хойд талд буюу хүдрийн V биетийн хойд талд байрлана. Хүдрийн IV биет нь 49м урттай, 25.0м хүртэл гүн үргэлжилсэн нэг биет тогтоогдсон бөгөөд зузаан нь 3.5 м байна.

Хүдрийн V биет нь байрлалын хувьд эрлийн 1-р талбайн хамгийн баруун талынх бөгөөд хүдрийн III биетийн баруун талд байрлана. Хүдрийн V биет нь 40м урттай, 31.0м **хүртэл** гүн үргэлжилсэн 1 биет тогтоогдсон бөгөөд зузаан нь 3.83 м байна.

**Хөрсний эзлэхүүн жин-2.67 тн/м3**

**Хүдрийн эзлэхүүн жин-2.5 тн/м3**

### Уурхайн ашиглалтын технологи

Ордыг ашиглах технологи нь уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтын болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, ашигт малтмалын нөөцийг зохистой ашиглахын зэрэгцээ төлөвлөгөөт бүтээлийг хангах ёстой. Иймээс ил уурхайг автотээвэртэй гадаад овоолго бүхий ашиглалтын технологоор ашиглана. 2026 онд төслийн дагуу зөвхөн ил уурхай олборлолт хийхээр тооцоо, төлөвлөлтийг хийлээ. Өрөмдлөг тэсэлгээний ажлыг гэрээт компаниар гүйцэтгүүлнэ. Ил уурхайн ашиглалтын технологийн үндсэн элементүүд, параметрийг хүснэгтээр үзүүлэв.

***Хүснэгт 3. Ашиглалтын технологийн үндсэн элементүүдийн параметрүүд***

| № | Ашиглалтын технологийн элементүүд | Хэмжих нэгж | Параметрүүд |
|---|---|---|---|
| 1 | Хөрс, хүдрийн ажлын доголуудын өндөр | м | 5 |
| 2 | Эцсийн байрлал дахь доголуудын өндөр | м | 10 |
| 3 | Уурхайн хажуугийн өнцөг | өнцөг | 38-40 |
| 4 | Ажлын бус доголын хажуугийн өнцөг | өнцөг | 65 |
| 5 | Ажлын доголын хажуугийн өнцөг | өнцөг | 65 |
| 6 | Аюулгүйн бермийн өргөн | м | 5 |
| 7 | Ажлын талбайн хамгийн бага өргөн | м | 30 |
| 8 | Хүдрийн хаягдал | % | 2.85 |
| 9 | Хүдрийн бохирдол | % | 4.28 |

### Ил уурхайн олборлох нөөц, ажиллах горим

Ордын тогтоогдсон геологийн С нөөц дээр тулгуурлагдан ТЭЗҮ-ийг боловсруулсан төслөөр уурхайн ашиглалтын үе шат болон эцсийн уурхайн дизайнууд, хүдрийн хаягдал, бохирдолын хувь хэмжээг ашиглан 3 хэмжээст блок моделоос ордын үйлдвэрлэлийн нөөцийг тодорхойлсон байна.

Төслийн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор хаягдал 2.85%, бохирдолт 4.28% байхаар тооцсон байх ба ил аргаар 196.55 мян.т хүдрийн нөөц олборлох боломжтой байна.

Уурхайн хүрээн дэх нийт уулын цулын хэмжээ 1.14 сая м.куб болсон байна.

***Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим***

| д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Хэмжээс | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Жилийн ажлын горим | Тасралтгүй | | |
| 2 | Жилийн календарь хугацаа | хоног | 365 | |
| 3 | Жилд ногдох ажлын бус хоног | хоног | 15 | Баяр ёслол, цаг агаарын саатал, төлөвлөгөөт бус сул зогсолт |
| 4 | Жилд ажиллах хоног | хоног | 350 | |
| 5 | Хоногийн ажлын горим | | 2 ээлж | |
| 6 | Ээлжийн хугацаа | цаг | 12 | |
| 7 | Хоногт ногдох ажлын нийт цаг | цаг | 24 | |
| 8 | Жилд ногдох ажлын нийт цаг | цаг | 8400 | |

***Хүснэгт 5. Уурхайн 2026 оны үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ***

| Геологийн нөөц | | | | | Бохирдол хүдэр 4.28% /тн/ | Хаягдал хүдэр, 2.85% /тн/ | Үйлдвэрлэлийн нөөц | | | | | Хөрс, м.куб | Уулын цул, м.куб | Хөрс хуулалтын коэф, м3/т |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүдэр, т | агуулга Li2O, % | агуулга Rb2O, % | Эрдэс Li2O, /тн/ | Эрдэс Rb2O, /тн/ | | | Хүдэр, т | агуулга Li2O, % | агуулга Rb2O, % | Эрдэс Li2O, /тн/ | Эрдэс Rb2O, /тн/ | | | |
| 119,485 | 0.77 | 0.14 | 925.56 | 168.94 | 5,114 | 3,405 | 121,195 | 0.74 | 0.14 | 899.18 | 164.12 | 575,131 | 620,500 | 4.7 |

Тус ордыг ашиглах 2026 оны төлөвлөгөөгөөр 121.2мян.тн хүдэр олборлож, 575,1мян.м3 хөрс хуулахаар 2026 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсрууллаа.

***Хүснэгт 6. Ил уурхайд ажиллах үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд***

| № | Үзүүлэлт | Марк | Хүчин чадал | Тоо, ш |
|---|---|---|---|---|
| **Үндсэн тоног төхөөрөмж** | | | | |
| 1 | Өрмийн машин | JK520 | Хошууны диаметр – 90-150 мм | 1 |
| 2 | Экскаватор | Hyundai-HX480 | Утгуурын багтаамж – 2.2 $м^3$ | 1 |
| 3 | Автосамосвал | Howo | Даац – 20 тн | 3 |
| 4 | Бульдозер | Shantui-SD13 | Хусуурын багтаамж -3.7 $м^3$ | 1 |
| 5 | Дугуйт ачигч | XCMG-ZL50 | Утгуурын багтаамж – 3.5 $м^3$ | 1 |
| **Туслах тоног төхөөрөмж** | | | | |
| 6 | Автогрейдер | CAT-160K | Хөдөлгүүрийн чадал – 216 кВт | 1 |
| 7 | Түлшний машин | Howo-Petrol truck | Багтаамж – 12 тн | 1 |
| 8 | Усны машин | Howo-Water truck | Багтаамж – 30 тн | 1 |
| 9 | Зөөврийн гэрэлтүүлэг | Light Plant | Тусгал –154 мян.лм | 3 |

***Хүснэгт 7. Өрөмдлөгийн ажил***

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | JK520 |
|---|---|---|
| Цооногийн диаметр | мм | 90-150 мм |
| Өрөмдлөгийн хамгийн их гүн | м | 40 |
| Хөдөлгүүрийн чадал | кВт | 75 |
| Түлшний савны багтаамж | литр | 250 |
| Масс | тн | 5.8 |
| Хөдөлгөөний хурд | км/цаг | 4.5 |
| Урт | мм | 7000 |
| Өргөн | мм | 2250 |
| Өндөр | мм | 2350 |



***Хүснэгт 8. Өрмийн машины бүтээл***

| Үзүүлэлт | Нэгж | JK520 |
|---|---|---|
| Хоногт ажиллах ээлжийн тоо | - | 2 |
| Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 12 |
| Хөдөлгүүрийн чадлаар нийт ажиллах хугацаа | цаг | 6545 |
| Өрмийн машины цагийн бүтээл | м/цаг | 22 |
| Ээлжийн бүтээл | м/ээлж | 264 |
| Хоногийн бүтээл | м/хон | 528 |
| Жилийн бүтээл | м/жил | 157,080 |
| Хуулах хөрсний хэмжээ | $м^3$ | 575100 |
| Олборлох хүдрийн хэмжээ | тн | 121200 |
| Нийт өрөмдлөгийн ажлын хэмжээ | Т.метр | 27000 |

**Тоног төхөөрөмжийн сонголт**

Ил уурхайд ажиллах экскаваторын сонгохдоо манай оронд өргөнөөр хэрэглэгдэж байгаа Caterpillar, Hitachi, Komatsu зэрэг фирмийн 3.5 м3 утгуурын багтаамжтай экскаваторуудын үнэ ашиглалтын зардал, техникийн үзүүлэлт, хүчин чадал, засвар үйлчилгээний ажлын хурдан шуурхай байдал, найдвартай ажиллагаа зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулалт хийх аргаар сонголт хийв. Тоног төхөөрөмжийн хувилбаруудын харьцуулалтыг дараах хүснэгтэд үзүүлэв.

***Хүснэгт 9. Тоног төхөөрөмжийн хувилбаруудын харьцуулалт***

| № | Грейдерийн техникийн үзүүлэлт | ҮЗҮҮЛЭЛТ | ҮНЭ /Сая.төг/ | ЖИЛИЙН БҮТЭЭЛ /МЯН.ТН/ | ШААРДЛАГАТАЙ ЭКСКАВАТОРЫН ТОО |
|---|---|---|---|---|---|
| 2 | CAT160K  | E=2.2 $м^3$<br>$R_у$=12.8 м<br>$R_{у.max}$=13.02 м<br>$H_{у.max}$=11.8 м | 600.0 | 580.5 | 1 |
| | Hitachi ZX-470L CH | E=2.5 $м^3$<br>$R_у$=13.82 м | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 |  | $R_{y.max}$=14.1 м<br>$H_{y.max}$=12.01 м | 550.0 | 430.5 | 1 |
| **4** | **CAT 349E L** | **E=2.5 м$^3$**<br>**$R_y$=10.7 м**<br>**$R_{y.max}$=12.9 м**<br>**$H_{y.max}$=11.1 м** | **815.5** | **731.0** | **1** |

**Ил уурхайн ашиглалтын систем**

**Ордыг ашиглах уул-геологийн нөхцөл ба ашиглалтын системийн сонголт**

Хөтөл-Улааны ордын талбай нь ерөнхийдөө дов толгодорхог газар болно. Газрын гадаргуугийн өндөржилт +1265 -1280м байна. Орд нь 0.8-3.1м зузаантай. Биетийн уналын өнцөг 56 - 64. Хүдрийн биетүүд нь 30м хүртэл гүнд тогтсон. Агуулагч чулуулаг нь харьцангуй бат бэх тогтоцтой, ан цав багатай, кварцжилт, цахиуржилтын хувиралтай зэрэг уул-техникийн нөхцөлтэй юм.

Уулын ажлыг ордын геологийн тогтоц, ашиглалтын технологи, уурхайн жилийн хүчин чадал, ордын ашиглалтын хэтийн төлөв байдал зэргийг үндэслэн тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар сонгож авав.

**Уурхайн хаягдал бохирдлын тооцоо**

**Хүдрийн хаягдлын тооцоо**

Уурхайн хил хязгаар доторхи хүдрийн биетүүдийн урт Биет -1 нь 60-80м, гүн 10-15м, биетийн гаршийн өргөн 4.5-3.2 м байна. Хүдрийн эзлэхүүн жин 3.0 т/м3 болно. Биетийн ул, таазнаас гарах хаягдлыг тус бүр 0.05м –ээр авав. Хаядлыг дараах байдлаар тооцоолов. Үүнд:

Биет-1 уурхайд

Биетийн ул ба таазны хаягдал: 2247м2 · 0.05м · 2 тал · 3.0 тн/м3 = 356.7тн

Биет-1 уурхайн нийт хаягдлын хэмжээ: 714.13 тн буюу 3.6% байна.

**Бохирдлын тооцоо**

Биетийн тааз болон уланд голдуу боржин байдаг. Боржингийн эзлэхүүн жин 3.2 тн/м$^3$ болно. Хүдрийн бохирдлын тооцоонд биетийн босоо, хэвтээ хажууг цэвэрлэх үед орох чулуулгийн хэмжээг 0.05 м зузаантай байхаар авч үзэв. Бохирдлын хэмжээг дараах байдлаар тооцоолов. Биет -1 -д.

Биет-1 уурхайд

Биетийн босоо, хэвтээ хажуугаас орох бохирдол: 2247м$^2$·0.05м·2 тал ·3.2 тн/м$^3$

Биет-2 уурхайн нийт бохирдлын хэмжээ: 474.2 тн буюу 3.8% байна.

**Уурхайн ажиллах горим ба ашиглалтын хугацаа**

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилийн 9 сарын турш, долоо хоногт амралтын хоёр өдөртэй, 10 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллуулахаар төлөвлөв. 12-р сараас 02-р сарыг дуустал ажилчдыг амраана. Уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар тооцоолов. Үүнд:

Жилийн нийт хоног – 365
Үндэсний баяр, ёслолоын хоног – 9
Амралтын хоног – 56
Цаг агаарын хүнд нөхцлийг тооцсон хоног – 7
Засвар үйлчилгээний хоног – 24
Уурхайн сул зогсолтын хоног – 89

Уурхайн жилд ажиллавал зохих хоног 365 - 9- 56 -7 -24-89 = 180 хоног байна.

Ил уурхайн ашиглалтын хугацаанд нийт 18.86 мян.тн хүчин чадлаар ашиглах нөхцөлд уурхай 2 жил үргэлжлэхээр байна. Ашиглалтын үеийн нэмэлт хайгуул хийж нарийвчилсан нөхцөлд уурхай цааш үргэлжлэх боломжтой.

**Төслийн дэд бүтэц**

Үйлдвэрийн бүрэлдэхүүн нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Ил уурхай
- Баяжуулах үйлдвэр
- Захиргаа, ажилчдын байрууд
- Цахилгаан хангамж /ТЭХНС/
- Усан хангамж /Гүний худаг/
- Засварын газар
- Хоолны газар /Сэндвич барилга/
- Уурхай орчмын замууд зэрэг багтана.

Уг төсөлд эдгээр барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудын холбогдох зардлыг хөрөнгө оруулалтын зардалд тусгасан болно. Хүний нөөцийн хувьд орон нутгийн ажилчдыг ажлын байраар хангах бодлогыг эхний ээлжид авч үзэх ба орон нутгийн иргэдэд сургалтын тэтгэлэг олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж байна.

**Цахилгаан хангамж:**

Ил уурхай болон угаан баяжуулах үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн цахилгаан хангамжийн үр ашигтай схемийг бий болгохын тулд уурхай болон баяжуулах үйлдвэрийн ажлын горим, технологи, механикжуулалд, цахилгаанжуулалтын бүхий л онцлогуудыг тусгана.

Уурхай болон баяжуулах үйлдвэр нь олон тооны цахилгаан хэрэглэгчидтэй бөгөөд тэдгээрийн суурилагдсан чадал нь ордын ашиглалтын нөөц, ордын байршил, уул техникийн нөхцөл, уурхайн хүчин чадал, үйлдвэрлэлийн процессын механикжуулалд зэргээс хамаарна.

Тус ордын уурхай болон баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Улаанбаатар Налайх дүүрэг Эрдэнэ сум Өвөр жанчивлан руу татсан 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас “Гурван төхөм” ХХК-ний алтны шороон орд хүртэл татсан 10 кВ-ын шугам ордын дэргэдүүр өнгөрдөг бөгөөд дээрх шугамаас уурхай хүртэл 500 м зайд 10 кВ-ын цахилгааны шугам татаж, 400 кВА хүчин чадалтай 10/0.4кВ-ын трансформатораас цахилгаан хэрэглэгчдийг эрчим хүчээр хангана.




**Зураг 2. Гадаад тээврийн замын маршрут**

***Уурхайн цахилгаан хэрэглэгчид***

Урт гозгорын хөндийн ордыг ашиглах ил уурхайн цахилгаан хэрэглэгчид нь:

- Ил уурхайд ажиллах цахилгаан хэрэглэгчид *(ус зайлуулах шахуурга, цахилгаан гэрэлтүүлэг)*
- Уурхайн тосгон (*ажилчдын байр, уурхайн захиргаа, халуун ус, хоолны газар)*
- Засварын газар бусад хэрэглэгчид *(Засварын газар, шатахуун түгээх станц, сэлбэгийн агуулах)* байх бөгөөд тэдгээрийг цахилгаан эрчим хүчээр хангах шаардлагатай.
- Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчид (*угаах төхөөрөмж, ширээ, шахуурга)* байх бөгөөд тэдгээрийг цахилгаан эрчим хүчээр хангах шаардлагатай.

**Уурхайн удирдлага зохион байгуулалт:**



**Ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа**

Ажиллагсдын байрлах байр, уурхайн захиргаа, цайны газар зэрэг дэд бүтцийн барилга байгууламжууд нь ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөл талбай дотор хамрагдана. Уурхай нь 1 жилийн хугацаанд ашиглах учир ажилчдын байрыг зөөврийн 12х3 м-н хэмжээтэй 8 хүн амьдрах боломжтой сэндвич байрнууд байхаар төлөвлөв. Хэдийгээр тус уурхайд тэргүүний дэвшилтэт технологитой, өндөр бүтээмжтэй тоног төхөөрөмж ажиллах боловч ажиллагсдын ажиллаж амьдрах тав тухтай нөхцөлийг бүрдүүлэхгүйгээр хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй юм.

Ажиллагсдын хотхон уурхайгаас зүүн хойд зүгт 900 м зайд байрлана. Уурхайн хотхонд удирдлагын байр буюу ажлын өрөө, нарядын байр буюу даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох газар, уурхайн ажиллагсдын цайны газар, авто машины засварын газар зэрэг барилга байгууламж байрлана. Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийх, зөвлөгөө өгөх, анхан шатны тусламж үзүүлэх эмийн сан бүхий цэг, эмчийн хувьд уурхай дээр орон тооны 1 бага эмч ажиллана. Шатахуун түгээх станц нь уурхайн хотхон болон бусад барилга байгууламжаас аюулгүй зайд баригдсан.



**Засварын газар**

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь уулын механик тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлнэ. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Уурхайн тоног төхөөрөмжийн агрегат ба автомашины засвар, техникийн үйлчилгээний хэсэг
- Механик цех
- Материал, сэлбэгийн агуулах
- Автомашины гарж

Эдгээр төхөөрөмжүүдийг сэндвич барилгад байрлуулах боломжтой бөгөөд дэргэд нь нэгэн зэрэг 1-3 автомашин, утгуурт ачигч зэргийн засвар хийх боломжтой зориулалтын зарим нэг тоног төхөөрөмжөөр тоноглосон сэндвич барилга барьж байгуулна.

*Засварын газар:* Уурхайн тосгоны дэргэд байрлах машин механизмын тоног төхөөрөмжийг засварлах, хуучин сэлбэгийг сэргээн засварлах, урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэхэд оршино. Нэгдсэн засварын цехийн тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмжийг иж бүрнээр сонгосон байна. Үүнд:

- Токарийн суурь машин
- Өндөр даралтын шланк базагч
- Өрмийн суурь машин
- Суурин гидравлик насос
- Суурин точил
- Аккумлятор цэнэглэгч
- Гагнуурын аппарат
- Хийн гагнуур
- Керосин зүсүүр тус тус байна.




*Зураг 3. Засварын газрын схем зураг*

Уурхайн техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг хангаж тэдгээрийн засвар үйлчилгээг ХАБЭА-н нэгдсэн дүрмийн дагуу зориулалтын байр болон зогсоолын газарт цаг алдалгүй хийх шаардлагатай байдаг.

**Гадаад тээвэр**

Баяжуулах үйлдвэрээс гарсан цагаан тугалганы баяжмалыг Улаанбаатар хот хүртэл 70 км зайд авто тээврээр тээвэрлэн, түүнээс цааш улсын урд хил хүртэл төмөр замаар тээвэрлэн БНХАУ-д экспортолно.

# 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1.Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

***Газрын гадаргуу:*** Хөтөл улаан нэртэй MV-015077 тоот нэртэй ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны нэгжийн хуваариар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт харьялагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 280 км, Даланжаргалан сумын төвөөс баруун хойш 25 километрийн зайд байршина. Хөтөл улаан талбай нь төмөр замын Өлзийт зөрлөгөөс зүүн тийш 3 км зайд, Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд холбосон авто замын хажууд, Шивээ-овоогийн нүүрсний уурхайгаас зүүн урагш 34 км, Далангийн нүүрсний ордоос баруун урагш 16 км-т, МАК-ийн үйлдвэрээс буюу 25-р зөрлөгөөс баруун хойш 10 км-т байрлах ба өндөр хүчдэлийн 10 кВт-ийн шугам талбайг дайран өнгөрдөг зэрэг дэд бүтцийн хамгийн таатай нөхцөлтэй бүс нутагт байрлаж байна. Тус талбай нь төмөр зам, авто зам дайран өнгөрдөг хөдөлгөөн ихтэй бүс нутаг тул малчид болон нутгийн оршин суугчид талбайгаас зайдуу нутагладаг.

***Усан сүлжээ:*** Судалгааны талбайн хэмжээнд тогтмол урсгал ус байхгүй, харин талбайгаас баруун талд 8 орчим километрийн зайнд Бэхтийн улаан нуур /1179.6м/ болон талбайгаас зүүн урагш 3 километрт Хөтлийн худаг, Цагаан нуур /1220.0м/ зэрэг нууруудтай.

Зуны улирлын сүүлч, намрын цагт үргэлжилсэн ширүүн борооны дараа хөндий, хуурай сайруудаар хэмхдэс чулуулаг зөөвөрлөсөн түр зуурын булингартай үерийн ус урсдаг. Нутаг дэвсгэрийн хүрээнд худаг, шанд харьцангуйгаар нэлээд элбэг. Худгийн усны нөөц тогтоогдоогүй, ундарга нь  дунджаар 0.2-0.8 л/сек.

Үүнээс гадна хүн, малын ундаанд удаан хугацаагаар ашиглагдаагүй дарагдсан буюу усгүй худаг, шандууд ч нэлээд тааралдана. Мөн эдгээрийн ихэнх нь эрдэсжилт ихтэй тул ундны хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй юм. Иймээс уурхайнууд ундны хэрэгцээт усаа суурин газраас, эрдэсжилт багатай томоохон төвлөрсөн худгуудаас авдаг.

***Цаг агаар, уур амьсгал:*** Хөтөл улаан талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтана. Цаг уурын статистик ажиглалт, судалгаагаар улирал, сар, хоногийн температур нь эрс хэлбэлздэг, хур тунадас бага, агаарын чийгшилт харьцангуй бага, хуурайвтар нөхцөлтэй.

Хамгийн бага дундаж температур нь нэгдүгээр сард -5-аас -250, хааяа -350 хүрдэг. Хамгийн их дундаж температур нь долоодугаар сард +130 -аас +250 байдаг. Дулааны улирал 9-р сарыг дуустал үргэлжилдэг.

Тус бүс нутагт хур тунадас бага унадаг, жилд дунджаар 100-170 мм хүрдэг. Үүний ихэнхи нь зуны улирлын сүүлч, намрын улирлын эхээр бороо ордогтой холбоотой ба өвөлд дунджаар 0.5-6.9 мм хур тунадас унадаг байна. Эх газрын баруун хойноос чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд дунджаар 2.8-7.3 м/сек-ийн хэлбэлзэлтэй, хаврын улиралд 10-12 м/сек, сүүлийн жилүүдэд хааяа 20-40 м/сек хүрч, хүчтэй шороон ба цасан шуурга шуурч, салхилдаг болжээ.

***Ургамлан нөмрөг:*** Хөрсний бүтэц нь  тархалт, зузаанаараа харилцан адилгүй тархалттай. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн, тал, нам дор газраа цайвар шаргал, хужирлаг, өндөрлөг газартаа улаан хүрэн, хүрэвтэр өнгийн хөрсүүд ялгагдана. Хүрэн цайвар, бор хүрэн хөрс нь голдуу элсэнцэр, шавранцар агуулах ба хужирлаг цайвар шаргал хөрс нь аллюви-нуурын гаралтай шавар, шавранцраас тогтоно.

Хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2 м. хааяа 0.3-0.4 м-т хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн

хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор, хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл, хажуу, нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн байдаг. Ургамлын бүрхэвчийг бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялгана, хазаар, агь, таана, хөмүүл, зангуу, божмог, шарилж зэрэг болно. Дов толгодын гуу жалга, хажуу бэл, нам дор газраар алтан харгана, хар харгана, дэрс, буйлс ургадаг ба хааяа зээргэнэ бага хэмжээгээр тааралддаг. Нутаг дэвсгэрийн хэмжээнд модлог ургамал байхгүй, нуур, булгийн эрэг орчмоор ургамлын бүрхэвч нь нэлээн шигүү, голдуу жалгын ургамал байна.

***Амьтны аймаг:*** Тухайн бүс нутагт ан амьтад харьцангуй элбэг, махчин амьтдаас үнэг, хярс, дорго, мануул, хааяа чоно, салаа туурайтнаас аргаль угалз, янгир, хавар намартаа зээр нүүдэллэн ирдэг ба мэрэгчдээс үлийн цагаан огтоно, ольби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Талбайн ойролцоо тарвага цөөн тоогоор тархсан. Даланжаргалан сумаас баруун урагш орших Их нартын хад нь говийн аргаль, янгирын байршлын хамгийн зүүн хойд хил болдог. Байгаль, түүхийн дурсгалт зүйл ихтэй энэхүү газрыг хамгаалах шаардлагатайг харгалзан УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор 43740 га газрыг байгалийн нөөц газарт бүртгэж хамгаалалтад авсан байна.

***Дэд бүтэц:*** Даланжаргалан сум нь төмөр зам, улсын босоо тэнхлэгийн замын дагуу, дэд бүтэц маш сайн хөгжиж буй дүүрэгт хамаарна. Тус сум 404.5 мян.га газар нутагтай, нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа Дорноговь аймгийнхаа Айраг, Иххэт сумдтай хиллэдэг.

Нийслэл Улаанбаатар хотоос 280 км, аймгийн төв Сайншанд хотоос 156 км зайтай оршино. Засаг захиргааны анхан шатны Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-Овоо гэсэн 5 нэгж багтай. 2013 оны байдлаар 2.7 мянган хүн амтай, 821 өрхтэй, 126.7 мян.толгой малтай, эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй, сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байна.

Бүс нутгийн хэмжээнд хүн ам сийрэг 1 км2 талбайд 0.2-0.6 хүн ам ноогддог. Нутгийн иргэд гол эрхэлдэг ажил нь мал аж ахуй, жижиг худалдаа, цөөн тооны иргэд сумын захиргаа, эмнэлэг, сургууль, холбоо болон ойролцоох уурхайнуудад ажилладаг.

Зундаа бусад газраас хүмүүс ирж гар аргаар жонш олборлодог. Тэдгээрийн тоо зарим үед 200 хүрдэг байна. Мөн зарим өрх айлууд хувиараа төв зам дагасан хоолны газар, зочид буудал, бусад жижиг үйлчилгээний газрууд ажиллуулдаг байна.

Даланжаргалан сум усан болон утаат болор, чүнчигноров, гартаам, мана, өнгөт чулуу, төмрийн хүдэр, ховор металл, нүүрс, хүрмэн чулуу, бал чулуу, шохойн чулуу, барилгын материалын түүхий эд зэрэг ашигт малтмал, газрын баялаг элбэгтэй, мөн авто зам, төмөр зам, харилцаа холбоо өргөн хөгжсөн нь эдийн засгийн томоохон давуу тал болж байна.

Хөтөл улаан талбайг улсын чанартай авто замаас дайран өнгөрдөг, төмөр замын Өлзийт өртөөнөөс 4.2 км зайд байрлаж, төвийн цахилгаан эрчим хүчинд холбогдсон. Үүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн баруун хойд хэсэгт 50 м зайд үүрэн телефоны дамжуулах станц байрлах ба талбайн аль ч хэсгээс үүрэн телефоны гар утас саадгүй нэвтэрнэ.

Даланжаргалан суманд “Мак” ХХК шохой чулуу, цеолитын орд, “Мон-Лаа” ХХК-ын Элдэв, Алаг толгойн нүүрсний орд, жоншны хэд хэдэн орд газрыг нээн илрүүлж геологи-хайгуулын ажлыг эрчимтэй явуулж байгаа нь бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна..

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 3.1.Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Хөтөл-Улаан нэртэй литийн рубидийн ордыг ил болон далд аргаар ашиглах төслийг хэрэгжүүлснээр байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг “Магадлан жагсаах” арга болон экспертийн үнэлгээний Матрицын аргыг хослуулан тодорхойлов. Үүнд:

Төсөл хэрэгжих хугацаанд байгалийн нөөц баялгийг зохистой, үр ашигтай ашиглах өнөөгийн нийгмийн шаардлагын дагуу, ашиглалтыг зохицуулах механизмуудыг боловсронгуй болгох, барилгын салбарт чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлэх ажлын хүрээнд үүсэж болох байгаль орчны сөрөг нөлөөллийн эрчим, цар хүрээг тодорхойлохыг гол зорилго болгон ажилласан байна.

Энэхүү үнэлгээний ажлыг Монгол улсын хууль тогтоомж, стандартуудын хүрээнд Байгаль Орчин Ногоон Хөгжлийн сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. БОННҮ-ний ажлын явцад гол нь литийг олборлох төслөөс байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүд, хаягдал болон технологийн горимыг нарийвчлан авч үзсэн болно. Эдгээр үзүүлэлтүүдийг газар дээр нь очиж дээж авч, авсан дээждээ хийсэн шинжилгээний үзүүлэлт дээр тулгуурлан үнэлгээ өгсөн болно.

Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байгаа, байхгүй гэсэн зарчим дээр үндэслэдэг бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэдэг. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд ямар байхыг үзүүлдэг байна. Нөгөө нь төслийн байршил, технологийн шийдэлтэй холбоогүй төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл юм.

***Хүснэгт 10. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл***

| Байгаль орчны үзүүлэлт | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Байгалийн экосистемийн өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын доорх урсцын өөрчлөлт | x | | | | x | | | x | | |
| Гадаргын урсцын өөрчлөлт | | | x | | | | | | | |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | x | | | | x | | | x | | |
| Хөрсний элэгдэл, эвдрэл | x | | | | x | | | x | | x |
| Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт | x | | | | x | | | | | |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт | x | | x | | | | | | | |
| 2. Байгалийн нөөц ашиглалт | | | | | | | | | | |

| Байгаль орчны үзүүлэлт | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Газрын гадаргын нөөц баялаг | x | | | | x | | | x | | |
| Бэлчээрийн байдал | x | | | | x | | | | x | |
| Эрдэс түүхий эдийн нөөц | x | | | | x | | | x | | |
| Эрчим хүчний нөөц | | | x | | | x | | | x | |
| 3. Байгаль, орчны өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын доорх усны чанар, хэмжээ | x | | | | | | | | x | |
| Гадаргын усны чанар хэмжээ | | | x | | | | | | | |
| Агаарын бохирдол | x | | | | | | | | x | |
| Хөрсний бохирдол | x | | | x | | | | x | | |
| Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх | x | | | | | | | x | | |
| Дуу чимээ, шуугианы нөлөө | x | | | | | | | | | |
| 4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор | | | | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх | x | | | | | | | | | |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | x | | | | | | | | | |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх | x | | | | | | | | | |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | | | x | | | | | | | |
| Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх | | | x | | | | | | | |
| 5. Нийгэмд үзүүлэх нөлөө | | | | | | | | | | |
| Хүн амын аюулгүй байдалд нөлөөлөх | | x | | | x | | | | x | |
| Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх | | | x | | x | | | | | x |
| Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх | | | x | | x | | | | x | |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх | | | x | | | | | | | |
| 6. Эдийн засагт үзүүлэх нөлөө | | | | | | | | | | |
| Татварын орлого өөрчлөгдөх | x | | | | x | | x | | | x |
| Төсвийг үр ашигтай зарцуулах | x | | | | x | | x | | | x |
| Ажлын байр нэмэгдэх | x | | | | x | | x | | | x |
| 7. Бусад нөлөөлөл | | | | | | | | | | |
| | | | x | | | | | | | |
| Дүн | 19 | 1 | 9 | 1 | 13 | 0 | 4 | 7 | 6 | 5 |

Байгалийн экосистемийн өөрчлөлт

Ил уурхайн олборлолтын хүчин чадал бага байх ба тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болон ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, геологийн тогтоц, агаарын бохирдолд шууд нөлөөлж, эдгээр нь урт хугацааны турш хүчтэй нөлөөлөлд хамрагдаж, ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Түүнчлэн тухайн орон нутгийн зэрлэг ан амьтад, шувууд үргэн дайжих, тоос шороо дэгдэх, бичил уур амьсгалын нөхцөлд урт, богино хугацаагаар бага зэрэг нөлөөлж болох юм.

Байгалийн нөөц, баялаг ашиглалт

Уурхайн үйл ажиллагааны гол зорилго нь байгалийн баялгийн нөөцийг олборлоход чиглэгдсэн бөгөөд нөлөөлөл нь шууд, буцалтгүй шинжтэй юм. Иймд байгалийн баялгийн нөөцийг олборлоход хаягдал багатай, байгаль орчныг нөхөн сэргээх ажил зэрэгцэн хийгдэхээр ажлын төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх үүрэг ноогдож байна.

Байгаль орчны чанарын өөрчлөлт

Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол нь байгалийн аясаар нөхөн сэргээгдэх чадвар удаан, элэгдэл эвдрэлд өртөмтгий, элсэн-сайр чулуун хучаа үе элэгдсэн тохиолдолд хөрсний эвдрэл идэвхэжнэ. Цаашид уул уурхайн ажил явагдах үед газрын хэвлийн эвдрэл үүсэж, элэгдлийн явц түргэсэж орчин тойрны ургамлын сан нөмрөгийг дарж устган цөлжилт үүсгэх сөрөг нөлөө гарч болзошгүй юм. Талбайн ургамлан бүрхэвч, ховор ан амьтан, ургамлыг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байна. Агаар, хөрсний бохирдлыг бага байлгах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай. Хогийн цэгийг технологийн дагуу хийж гүйцэтгэх хэрэгтэй.

Байгалийн өнгө төрх түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор

Литийн рубилийн ордыг ил далд аргаар олборлох үед байгалийн өнгө төрх өөрчлөгдөн газрын хэвлийд хөндий нүх үүсэх, ойр орчмын газрын хөрс, ургамлан нөмрөг технологи ажиллагаатай холбоотойгоор эвдрэлд орох зэргээр шууд бөгөөд урт хугацааны нөлөөлөл бий болж, нэлээд хүчтэй нөлөөлөх хүчин зүйлийн тоонд оруулж болно.

Эдийн засаг нийгмийн асуудал:

Уурхайн үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах бөгөөд ажлын байр бий болж, орон нутгийн иргэдийн амьжиргаанд тус нэмэр болох сайн талтай юм. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

Болзошгүй шууд нөлөөлөл:

- Хөрс хуулах, литийг олборлох, зам гаргах үед хөрсний эвдрэл үүсэх, түүнд өртсөн ургамлан нөмрөг, биологийн төрөл зүйл устах, суларсан хөрс шорооноос агаарын бохирдол үүсэх,
- Тодорхой хэмжээгээр бэлчээрийн талбай хоргодох,
- Байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан хүчтэй салхи, газар хөдлөл, үер зэрэг байгалийн гамшиг бий болох,
- Ажиллагсдын хайнга ажиллагаанаас гал түймэр гарах,
- Хатуу, шингэн хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулаагүйгээс орчин бохирдох,
- Шатах, тослох материал асгарснаас орчин бохирдох,
- Шатах, тослох материалын ууршилтаас агаарын бохирдол үүсэх,
- Уурхайн машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх, Болзошгүй шууд бус нөлөөлөл
- Литийн бичил биетэн, биологийн төрөл зүйлд нөлөөлөх,
- Хөрс хуулалт болон олборлолтоос шалтгаалан хөрсний үржил шим алдагдах,

Урт хугацааны нөлөөлөл

Лити олборлолтоос үүдэн гарах урт хугацааны нөлөөлөл нь хөрсний эвдрэл, ургамлан нөмрөг устах зэрэг асуудал болно. Иймд нөхөн сэргээлтийн ажлыг чанартай хийх шаардлагатай.

Богино хугацааны нөлөөлөл

Орчны дуу чимээ ихсэх, агаарын бохирдол түр хугацаагаар үүсэх, ус хэрэглээнээс цэвэр усны нөөц богино хугацаанд өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл үүнд хамаарна.

Эрчимтэй нөлөөлөл

Нарийвчилсан үнэлгээний үр дүнгээс үзэхэд литийн рубдидийн олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа нь шохойн чулууны орд газрын хөрсний эвдрэл, агаарын бохирдол юм.

Бусад нөлөөлөл

Энэ төрлийн нөлөөлөл газар ашиглалт болон ахуйн хаягдалтай холбогдолтой зүйлүүдийг оруулав. Газар ашиглалтын холбоотой нөлөөлөлд хөрсний элэгдэл, байгалийн гамшгийг (хүчтэй салхи, үер, газар хөдлөлт гэх мэт) оруулдаг байна. Олборлолт хийх газар орчмын хөрсний элэгдэл нь машины олон салаа зам гаргах, агаарын тоосжилтоос ургамлан бүрхүүл хомсдох, усны үер болон салхины хурднаас шалтгаалдаг байна. Түүнчлэн ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материал хөрсөнд алдагдах, нэвчих, ахуйн хаягдлын ариутгал муу, ариун цэврийн дэглэм сахиагүйн улмаас халдварт өвчин гарах, галын аюулд өртөх явдлаас аль болохоор сэргийлэх зэрэг холбогдох арга хэмжээг байгаль хамгаалах төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай болно.

# 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-н 9-р зүйлд зааснаар Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний салшгүй хэсэг юм. “Талст дисковери” ХХК-ийн “Хөтөл улаан литийн рубидийн ордыг ил болон далд аргаар ашиглах” төслийн БОМТ-г Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХЯ-ны сайдын 2014 оны 04 дугаар сарын 10-ний А-117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд “Хөтөл улаан нэртэй” литийн рубидийн ордыг ил далд аргаар олборлоход үүсэх нөлөөллийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц зохион байгуулалтын схем, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хариуг үндэслэн жил бүр шинэчлэн, сайжруулж байх шаардлагатай юм.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчны менежмент төлөвлөгөөний гол зорилт, арга хэмжээ, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг орон нутгийн болон олон нийтийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын дагуу дахин хянаж нарийвчилна.

***Хүснэгт 11. 2026 онд хэрэгжүүлэх  Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал***

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Нийт зардал, мян.төг |
|---|---|---|
| 1. | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 6480,0 |
| 2. | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 10000,0 |
| 3. | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | 7000,0 |
| 4. | Түүх соёлын өвийг хмагаалах | 500,0 |
| 5. | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 14800,0 |
| 6. | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 5386 ,0 |
| 7. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 3134,0 |
| 8. | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 6000,0 |
| | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал | **53300,0** |

# 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

***Хүснэгт 12. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ***

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Хамрах хүрээ | Нэгж үнэ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. |
| **Агаар орчин** | | | | | | | |
| 1. | Хөрс хуулалт, барилга байгууламж барих, жонш олборлох, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсэж төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө. | Уурхайн авто замуудыг болон олборлолтын талбайн тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх (Дулааны улиралд усалгааг тогтмол хийх) | Уурхайн зам, олборлолтын талбай | Үйл ажиллагааны зардал | | 2026 онд | **MNS ISO 4227:2002,** “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”, **MNS 4585-2016,** “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”, **MNS 5885:2008,** “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”, **MNS 6063:2010,** “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”, |
| 2. | Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт үүсэж агаарын чанарт сөргөөр нөлөөлөх | Хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах | Уурхайн дотоод замын шаардлагатай хэсгүүдэд | 50,0*10 | 500,0 | 2026 онд | |
| 3. | | Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замын арчилгаа тордолгоо хийх | Уурхайн дотоод зам | Үйл ажиллагааны зардалд тусгах | | 2026 онд | |
| 4. | Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникүүд агаар орчныг бохирдуулж болзошгүй | Уурхайн үйл ажиллагаа болон барилгын ажилд ашиглагдаж байгаа бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх | Уурхайд ашиглагдаж буй нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм | Үйл ажиллагааны зардалд тусгах | | Сард нэг удаа 2026 онд | |
| **Усны нөөц, чанар** | | | | | | | |
| 5. | Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын доорх усны түвшин буурах | Ил уурхайд шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг багасгах зорилтоор ашиглах | Үйл ажиллагааны хүрээнд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | 2026 онд | “Усны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баримталж ажиллах **MNS 0899-1992**, “Унд, ахуйн зориулалттай усны |
| 6. | | Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх | Үйл ажиллагааны хүрээнд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | 2026 онд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | | Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу тооцож, тогтоосон хугацаанд нь төлөх | Үйл ажиллагааны хүрээнд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | 2026 онд | төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага” **MNS 0900-2018,** “Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7- р тогтоол) **MNS 4943-2018,** “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус” |
| **8.** | | Усны бүх эх үүсвэрүүдийг тоолууржуулах | Нийт ажилчдыг хамруулах | 1000,0 | 1000,0 | 2026 онд | |
| **9.** | | Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгаар ажилчдад сургалт орох | | 500,0 | 500,0 | 2026 онд | |
| **Хөрсөн бүрхэвч болон газрын гадарга** | | | | | | | |
| 10. | Ил уурхай, овоолго болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох, газрын хэвлий эвдрэх | Аливаа газар хөндөх үйл ажиллагааны үед үржил шимт хөрсийг урьдчилан 0.2-0.35 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах | Уурхайн үйл ажиллагааны хүрээнд | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан | | 2026 онд | **MNS 3985:1987** Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. **MNS 5850:2006** Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. |
| | | Шимт, шимэрхэг хөрсний овоолгуудын байршил, хэмжээг бүртгэх, газарзүйн мэдээллийн системд зурагжуулах | Уурхайн үйл ажиллагааны хүрээнд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | 2026 онд | |
| 11. | | Шимт болон шимт хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв сонгох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (3 метрээс өндөргүй овоолох) | Уурхайн байршилд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | 2026 онд | |
| | | Хадгалсан шимт, шимэрхэг хөрсийг, ногоон байгууламжид эргүүлэн ашиглах | Уурхайн үйл ажиллагааны хүрээнд | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан | | 2026 онд | |
| 12. | Уул уурхайн үйл ажиллагааны явцад хүнд даацын техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөр хөрсний элэгдэл, эвдрэл нэмэгдэх, доройтох, талхлагдах, | Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замыг дагтаршуулах | Уурхайн дотоод төв замууд | 500.0 | | 2026 онд | |
| 13. | | Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, онц шаардлагагүй олон салаа | Уурхайн дотоод төв замууд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | 2026 онд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлэх | | | | | |
| 14. | Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, хөрсөнд нэвчих, хөрс бохирдох | Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах | Шатахуун түгээх станц, засварын газар, авто зогсоол | 1200,0 | 1200,0 | 2026 онд | |
| 15. | | Асгаралтаас урьдчилан сэргийлэх дотоод журам боловсруулж, асгаралтаас урьдчилан сэргийлэх асгаралт гарсан тохиолдолд иж бүрдлийг хэрхэн ашиглах талаар сургалтыг тогтмол явуулах | Төслийн талбайн шаардлагатай байршлуудад | Сургалтын зардлаар | | 2026 онд | |
| **Ургамлан бүрхэвч, зэрлэг ан амьтан болон мал сүрэгт** | | | | | | | |
| 16. | Уурхайн машин техникээс гарах тоос, утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулах | Уурхайн авто замуудыг дулааны улирал болон тоос ихээр босох үеүдэд усалгаа хийж, чийгшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Төслийн талбай дахь замуудад | Агаарын чанарын хэсэгт тусгагдсан | | 2026 онд | |
| 17. | Ургамлын төрөл зүйл хомсдох | Ногоон байгууламж байгуулах . усалгаа арчилгаа хийх | Ажилчдын амрах байрны ойр орчим | 40,0*50 | 4000,0 | 2026 онд | |
| **Амьтны аймаг** | | | | | | | |
| 18. | Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур | Биотехникийн арга хэмжэээ зохион байгууллахад сумтай хамтран ажиллах | Төслийн талбайн ойр орчимд болон замын дагуу | 20 боодол *14 | 500,0 | 2026 онд | |
| 19. | | Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг ашиглахыг хориглох тухай ажилчдад мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах | Төслийн талбайн ойр орчим | 1*280 | 280,0 | 2026 онд | |
| **НИЙТ (мян.төг)** | | | | | | **7480,0** | |

# 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж байгаа билээ. Энэхүү хөдөлгөөний хүрээнд “Талст дисковери” ХХК нь ашиглалтын талбай доторх боломжтой газруудад мод тарих, ногоон байгууламж байгуулахаар төлөвлөн энэхүү бүлэгт орууллаа. 2026 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2026 онд техникийн нөхөн сэргээлт хийх боломжгүй байна.

***Хүснэгт 13. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө***

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. |
| 1. | Ногоон байгууламж | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран, газар заалган мод тарих | ш | 500 | 20.0 | 10000,0 | 2026 онд | MNS 5917:2008 MNS 5915 : 2008 |
| 2. | Нөхөн сэргээлтийн зардал | 2026 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2026 онд | х | х | х | х | х | |
| | | 2026 оны төлөвлөгөөний нийт зардал | | | | | 10000,0 | |

## 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэдэг нь байгалийн газарзүйн тогтцын хувьд төсөөтэй газар нутгийг сонгон авч биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэйгээр сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн үр дүн болно. Төлөвлөгөөг мэргэжлийн байгууллага ажиллуулахгүй уурхайн дарга болон байгаль орчны мэргэжилтэн төлөвлөн стратеги төлөвлөгөө боловсруулахаар тооцсон болно.

**Хүснэгт 14. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний хүрээ, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал Төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэх тухайн алдагдлыг өөр байршилд эсвэл өөр хэлбэрээр тэнцвэржүүлэн нөхөх, хамгаалах | Сум орон нутгаас өгсөн арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Даланжаргалан сумын байгаль орчнинтой хамтран тайлбайг сонгох | 1 | Үйл ажиллагааны зардлаар | Тухайн жилд |
| | Нийт | | 7000,0 | | | |

# 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Талст дисковери” ХХК-ны Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих Хөтөл-Улаан жоншны орд ашиглах төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

# 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёлын өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

***Хүснэгт 15. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө***

<table>
<tr><th>№</th><th>Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв</th><th>Хамгаалах арга хэмжээ</th><th>Арга хэмжээний цар, хэмжээ</th><th>Тоо хэмжээ</th><th>Нэгжийн зардал, төг</th><th>Нийт зардал, төг</th><th>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</th><th>Баримтлах эрх зүйн баримт бичиг</th></tr>
<tr><td></td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td><td>8</td></tr>
<tr><td>1</td><td>Археологийн дурсгал</td><td rowspan="2">Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.</td><td rowspan="2">Уурхайн ашиглалтын нийт талбайн хэмжээнд</td><td rowspan="2">1</td><td rowspan="2" colspan="2">Тухайн үед нь шийдэх</td><td rowspan="2">Үйл ажиллагааны турш</td><td rowspan="2">Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/ , Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд</td></tr>
<tr><td>2</td><td>Палеонтологийн дурсгал</td></tr>
<tr><td></td><td colspan="5">Нийт</td><td>500,0</td><td></td><td></td></tr>
</table>

# 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

***Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө***

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн өртөг, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. |
| 1. | | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дагаж мөрдөх | Төслийн үйл ажиллагаа ы үед | Үйл ажиллагааны зардалд тусгах | | | Шаардлага гарсан үед | Монгол улсын шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар |
| 2. | | ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх | Ажилчид болон орон нутгийн иргэд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | | 2026 он сар бүр | Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ |
| 3. | Газар хөдлөл | Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний | Ажилчид | 1 000.0 | 1 | 1 000.0 | 2026 онд | MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага.<br>MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн |

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн өртөг, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах, | | | | | | сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага. MNS 4970:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ. MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. |
| 4. | Аянга цахилгаан | Хамгаалах газардуулгын байгууламж буюу тэглэлтийн стандартаар тогтоосон шаардлагыг ашиглалтын үед тогтмол шалгаж нийцүүлж байх | Эрчим хүчний байгууламж ,Шатахуун түгээх станц | - | - | - | 2026 онд | |
| 5. | | Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах | Төслийн талбай | Үйл ажиллагааны зардалд тусгах | | | 2026 онд | |
| 6. | Үер | Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах. | Төслийн талбай | 2000,0 | | 2000,0 | 2026 онд | |

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн өртөг, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Гал түймэр | Галын аюулын талаар анхааруулга самбарыг галын сарайны хажууд байршуулах | Төслийн талбай | 200,0 | 2 | 400,0 | 2026 онд | |
| 8. | Халдварт өвчин | Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах, ажилчдыг хувийн эрүүл ахуйн дадал зуршлыг хэвшүүлэх сургалт зохион байгуулах | Төслийн ажилчид | 500.0*1 | | 500.0 | 2026 онд | |
| 9. | Үйл ажиллагааны осол гэмтэл | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах | Төслийн ажилчид | 40*250=10000.0 | | | 2026 онд | |
| 10. | | Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, | Төслийн ажилчид | ХАБ мэргэжилтэн уурхайн даргын цалингийн зардлаар | | | 2026 онд | |
| 11. | | Анхны тусламжийн эмийн сан байршуулах | Ажилчдын байр | 300,0*3 | | 900,0 | 2026 онд | |

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн өртөг, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12. | Автомашины осол | Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд жолоочид авах арга хэмжээний тухай бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах | Тээврийн хүнд машин механизм болон тээврийн хэрэгслүүд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | | 2026 онд | |
| 2026 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал | | | | | 14800,0 | | | |

# 11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ахуйн хог хаягдлыг (цаас, баглаа боодлын хайрцаг, хуванцар сав, металл, төмөр, шил, нийлэг материал г.м) ангилан түр хадгалах хогийн саванд цуглуулна. Ахуйн болон бусад хатуу хог хаягдлыг ангилсны дараагаар дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаана. Ашигласан тосыг битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна. Хаягдал зайлуулах нүх/савыг сард нэгээс доошгүй удаа ариутгах ба бие засах газар, шүршүүрийг өдөр бүр цэвэрлэж, ариутгана. Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар бохир усны нүх, сав, бие засах газрыг ариутган булж тэгшлэн нөхөн сэргээнэ. Ажилчдын хариуцлагагүй байдал, машин техникийн эвдрэл гэмтэл зэргээс хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан авч, тусгаарлагч гадаргуу дээр овоолон, 18-22%-ийн хлорт уусмалаар бороожуулж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээг 0.05 мг/кг-аас ихгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд буцаан байршуулна. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаар зохицуулагдаж байна. Энэхүү төслийн хүрээнд хайлуур жонш олборлох явцад төсөл хэрэгжүүлэгч дараах эрх эдэлж үүрэг хүлээнэ.

- Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;
- Хог хаягдлыг дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;
- Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах;
- Аюултай хог хаягдлыг бусад төрлийн хог хаягдалтай хамт тээвэрлэхгүй байх;
- Хог хаягдлыг зориулалтын саванд хийж, зориулалтын хогийн цэгт хаях;
- Ил задгай хог хаягдал шатаахгүй байх;
- Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон тусгай цэгт устгах болон хуульд заасан бусад эрх, үүрэг

***Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө***

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах | Хог хаягдлын гэрээг Далан сумын ЗД грээ байгуулах төлбөр төлөх | Төслийн хэмжээнд | Ширхэг | 1200,0 | 1 | 1200.0 | 2026 оны 2-р улиралд | Хог хаягдлын тухай хууль хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэх |
| 2 | Хатуу болон шингэн хог хаягдал | Ахуйн гаралтай хог хаягдлын ангилан ялгаж байх | Төслийн хүрээнд | Ширхэг | 400 | 5 | 2000.0 | 2026 он | |
| 3 | | Ангилан ялгасан хог хаягдлыг улиралд нэг удаа Эко говь дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | Төслийн хүрээнд | кг | - | - | 786,0 | 2026 он | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шингэн хаягдал | Бохир ус соруулдаг байгууллагаар соруулан зайлуулах | Нүхэн жорлон | удаа | 50,0 | 12 | 600.0 | Сар бүр удаа | Хог хаягдлын тухай хууль |
| 2 | Аюултай хог хаягдал | Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумляторыг тусгай цэг гарган төслийн талбайд 150 хоног хадгалан дахин ашиглах цэгт хүргүүлж байх | Засварын газарт | - | - | - | 400,0 | 2026 он | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын |
| 3 | Жорлон, ариун цэврийн өрөө | Ажилчдын ариун цэврийн өрөө, жорлонг ариутгалын бодисоор ариутгах | Жорлон | ш | 80 | 5000 | 400.0 | Сар бүрийн эхний 10 хоногт | ХАБ, ЭА ахуй , БО, Эрүүл ахуйн шаардлага |
| 2026 ОНЫ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ | | | | | | | | 5386,0 | |

## 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна. Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төсөл хэрэгжүүлэх явцад “Өгөөж Их Орд” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04-дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

***Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр***

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж | Шаардагдах зардал (мян.төг) | Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|---|---|---|---|---|---|
| Агаарын чанар | | | | | |
| 1. | Агаарт хаягдах түгээмэл бохирдуулагчид($NO_2$, $SO_2$, CO)-ын агууламжид хяналт тавих, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх | Уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай нийт 1 цэгт (уурхайн олборлолтын талбай, овоолго, дотоод тээврийн зам, уурхайн тосгон) | Жилд 2 удаа | 1000 | ❖ MNS 4585: 2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага<br>❖ MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага<br>❖ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага<br>❖ MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ |
| 2. | Агаарын тоос, тоосонцрын (TSP, $PM_{10}$, $PM_{2.5}$) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | | | | |
| 3. | Дуу шуугиан, чичиргээ | | | | |
| Усны хяналт шинжилгээ | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4. | Усны ерөнхий химийн шинжилгээ, физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, | Уурхай ашиглалтын худаг-1, уурхайн шүүрлийн ус-1 | Жилд 2 удаа | химийн шинжилгээ 75.0<br>Усны 10 элемент хүнд металлын шинжилгээ 48.0<br>(УСУГ итгэмжлэгдсэн лаборатори, Ханлаб ХХК, Инженер геодези ХХК , Геоэкологийн<br>123*3=369*2=738 | ❖ MNS 0900: 2018, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ<br>❖ MNS 6148:2010 Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS 4943:2008 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага<br>❖ MNS ISO 10523-2:2003 pH тодорхойлох<br>❖ MNS ISO 4889-99 Цахилгаан дамжуулах чанар тодорхойлох<br>❖ MNS ISO 6059:2005 Хатуулаг тодорхойлох<br>❖ MNS ISO 2572-99 Кальци тодорхойлох<br>❖ MNS ISO 9297:2005 Хлорид, тодорхойлох<br>❖ MNS 4425:97 Гидрокарбонат тодорхойлох тавих хяналт |
| 5. | Усны хүнд металлын шинжилгээ | Уурхай ашиглалтын худаг-1, Уурхайн шүүрлийн ус | Жилд 2 удаа | | |
| 6. | Септик танк ашиглан цэвэршүүлсэн усны биологийн хэрэгцээт хүчилтөрөгч болон химийн хэрэгцээт хүчилтөрөгч | Цэвэршүүлсэн ус | Жилд 2удаа | | |
| Хөрсний бохирдол | | | | | |
| 7. | Хөрсний үржил шимийн үзүүлэлт (pH, ялзмаг, карбонат, Ca2+ Mg2+, $K_2O$, $P_2O_5$ ) механик бүрэлдэхүүн, хүнд металлууд Cr, Pb, Cd,Ni Zn | Шимт хөрсний овоолго -1, хөрсний овоолго-1, ажилчдын тосгон-1, засварын газрын гадна-1 нийт 4 цэгт хөрсний хяналт мониторингийг хийнэ. | Жилд 2 удаа | Механик бүрэлдэхүүн 120.0<br>Хүнд металл: 150.0<br>(Грийн лаб ХХК-ийн үнэ болно.)<br>Нянгийн үзүүлэлт 178.0<br>(ШУА-ийн Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэнгийн үнэ<br>Нийт: 896.0 | ❖ MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ<br>❖ MNS 3310:91, Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох<br>❖ MNS 3298:1990 хөрсний шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага<br>❖ MNS 3307:91, хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга<br>❖ MNS ISO 10390, Хөрсний чанар. pH тодорхойлох<br>❖ MNS 4006:1988, Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох<br>❖ MNS 2143:2000, Хөрсний физик шинж чанарыг тодорхойлох арга |
| Томилолтын зардал | | | | | |
| 8. | ОХШ хийлгэх томилолтын зардал | ОХШ хүрээдн | Жилд 1 удаа | 500.0 | Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй |
| 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын нийт зардал | | | | | 3134,0 |

# 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хайлуур жоншны орд ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар Газрын чанарын улсын хянан баталгааг хийлгэх шаардлагатай.

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага
- Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт

Эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг аймгийн БОГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, Онцгой байдлын газар /ОБГ/, зэрэг байгууллагуудаар төслийн үйл ажиллагаанд хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд: Төслийн ажилчид, албан хаагчдыг үр бүтээлтэй, осол авааргүй ажиллуулах тулд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээг цаг тухай төлөвлөн, ажиллагсдад улирал бүр зааварчилгаа өгүүлэх, үе шаттайгаар хянан шалгах арга хэмжээнүүдийг өөртөө багтаасан Компанийн Хөдөлмөр Хамгаалал, Аюулгүй Ажиллагааны (ХХАА) системийг бий болгож түүн дээр үндэслэн, олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын шаардлагуудад нийцсэн журам стандартуудыг харьялагдах байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан (Монгол улсын засгийн газраас 2005 онд баталсан ХХАА, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2.1.4, 2.1.6 заалтад тулгуурлан) мөрдөж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр

ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөлөө.

*Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал | Хэрэгжүүлэх хуваарь |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | | 2026 онд |
| 2 | Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах | 500*2 | 1000.0 | 2026 онд |
| 3 | Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах | Дотоод зардлаар | | 2026 онд |
| 4 | Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх | 5000,0 | 5000,0 | 2026 онд |
| 5 | Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах | Осол эрдсдлын төлөвлөгөөнд тусгагдсан | | 2026 онд |
| 6 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлуудын жил бүрийн тайланг БОАЖЯ болон аймгийн БО газарт хүргүүлэх | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | | 2026 онд |
| 7 | Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | | 2026 онд |
| 2026 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал | | 6000,0 | | |

## 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 19. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө*

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Байгаль Уур Амьсгалын Өөрчлөлтийн яам яам | БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна | Жил бүрийн 12 дугаар сарын 01-ээс өмнө | Үйл ажиллагааны зардалд тусгах | Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн Байгаль орчны мэргэжилтэн болон ХАБЭА | Улаанбаатар хот |
| 2. | Дорноговь аймгийн байгаль орчны газар | Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт | | Жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс өмнө | | | Дорноговь аймаг |

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

## АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***MV-015077***

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн ***Дорноговь*** аймаг /хот/-ийн ***Даланжаргалан*** сум /дүүрэг/-ын ***Хөтөл улаан*** нэртэй газарт орших ***354.67*** гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн ***9011854786*** тоот гэрчилгээтэй ***“Талст дисковери” ХХК***-д энэхүү тусгай зөвшөөрлийг ***2039.08.20*** дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТМАГНАЙ

2023 оны 08 дугээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

0000697

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-015077**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Хөдөлгөөний код | Хөдөлгөөний тайлбар | Гарын үсэг, огноо, тамга |
|---|---|---|
| 000-CI | • Бүртгэв: Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хэрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон. | 2010-04-01 |
| 002-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2010.08.20 – 2011.08.20 хүртэл | 2010-07-23 |
| 003-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2011.08.20 – 2012.08.20 хүртэл | 2011-08-20 |
| 004-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2012.08.20 – 2013.08.20 хүртэл | 2012-06-27 |
| 005-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2013.08.20 – 2014.08.20 хүртэл | 2013-08-02 |
| 006-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.08.20 – 2015.08.20 хүртэл | 2014-08-11 |
| 007-TF | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9019078061 тоот улсын бүртгэлийн дугаартай Дунщинхэние ХХК-д шилжүүлэх<br>• Кадастрын хэлтсийн даргын 2015.01.08-ны 11 тоот шийдвэр | 2015-01-08 |

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-015077**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 008-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.08.20 – 2016.08.20 хүртэл | 2015-08-20<br>01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС АТХ0058 |
| 009-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.08.20 – 2017.08.20 хүртэл | 2016-07-29<br>01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС АТХ0058 |
| 010-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 9 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.08.20 – 2018.08.20 хүртэл | 2017-08-02<br>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0535 |
| 011-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 10 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.08.20 – 2019.08.20 хүртэл | 2018-07-20<br>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0555 |
| 012-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2019.08.20 – 2020.08.20 хүртэл | 2019-08-02<br>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0555 |
| 013-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 12 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.08.20 – 2021.08.20 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС<br>2020.09.15 |
| 014-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 13 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.08.20 – 2022.08.20 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС<br>20[illegible].08.11 |

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

**MV-015077**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 015-FE | • Баталсан: Тусгай зөвшөөрлийн 14 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.08.20 – 2023.08.20 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2022.08.02 |
| 016-FE | • Баталсан: Тусгай зөвшөөрлийн 15 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.08.20 – 2024.08.20 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2023.08.17 |
| 017-FE | • Баталсан: Тусгай зөвшөөрлийн 16 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2024.08.20 – 2025.08.20 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2024.08.09 |
| 018-FE | • Баталсан: Тусгай зөвшөөрлийн 17 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2025.08.20 – 2026.08.20 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2025.02.03 |
| | | |
| | | |
| | | |

**15077A**

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . . . . . . ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

(тусгай зөвшөөрөлгүй бол хүчингүй)

*Тусгай зөвшөөрлөөр талбайн хэмжээ болон тусгай зөвшөөрлийн эзэмшилд орсон өөрчлөлт*

| д/д | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Өргөдлийн бүртгэлийн дугаар | Хасагдах талбайн хэмжээ (га-аар) | Үлдсэн талбайн хэмжээ (га-аар) |
|---|---|---|---|---|
| 1. | Анх олгосон | 23964A | | 354.97<br>2009-08-20 |

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

**MV-015077**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Хөдөлгөөний код | Хөдөлгөөний тайлбар | Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/ | Хасагдах талбайн хэмжээ /га/ | Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, гарын үсэг, огноо, тамга |
|---|---|---|---|---|
| 000-CI | • Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон. | 354.67 Га | 0 Га | 1 108° 50' 31.62" 46° 0' 1.65"<br>2 108° 49' 11.62" 46° 0' 1.65"<br>3 108° 48' 51.61" 46° 0' 41.65"<br>4 108° 48' 51.61" 46° 0' 51.66"<br>5 108° 49' 17.62" 46° 0' 51.66"<br>6 108° 49' 17.62" 46° 1' 1.65"<br>7 108° 50' 31.62" 46° 1' 1.65"<br>2010-04-01 Э. Заяабат |
| 007-TF | • Тусгай зөвшөөрлийг 9019078061 тоот улсын бүртгэлийн дугаартай Дүншинхэние ХХК-д шилжүүлэх Шийдвэрийн огноо: 2015.01.08 | 354.67 Га | 0 Га | 1 108° 50' 31.62" 46° 0' 1.65"<br>2 108° 49' 11.62" 46° 0' 1.65"<br>3 108° 48' 51.61" 46° 0' 41.65"<br>4 108° 48' 51.61" 46° 0' 51.66"<br>5 108° 49' 17.62" 46° 0' 51.66"<br>6 108° 49' 17.62" 46° 1' 1.65"<br>7 108° 50' 31.62" 46° 1' 1.65"<br>2015-01-08 Ш.Мандахжаргал |

**15077А**

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ......... ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 2 ДУГААР ХАВСРАЛТ

(тусгай зөвшөөрөлгүй бол хүчингүй)

*Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын өөрчлөлтүүд*

| д/д | Солбицлууд өөрчлөгдөх үндэслэл | Хүчин төгөлдөр солбицлууд |
|---|---|---|
| 1. | Талбайн солбицлууд | |

| No | град | мин | сек | град | мин | сек | No | град | мин | сек | град | мин | сек |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 108 | 48 | 50 | 46 | 0 | 40 | 5 | 108 | 50 | 30 | 46 | 1 | 0 |
| 2 | 108 | 48 | 50 | 46 | 0 | 50 | 6 | 108 | 50 | 30 | 46 | 0 | 0 |
| 3 | 108 | 49 | 16 | 46 | 0 | 50 | 7 | 108 | 49 | 10 | 46 | 0 | 0 |
| 4 | 108 | 49 | 16 | 46 | 1 | 0 | | | | | | | |

2009-08-20 Э.Занабат

АМГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТР...

“ТАЛСТ ДИСКОВЕРИ” ХХК -Д

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Арцатын 624, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2024.10.24 № 12/4945

танай ____________-ны №____________-т

Ерөнхий үнэлгээний дүгнэлт хүргүүлэх тухай

Танай байгууллагаас боловсруулан ирүүлсэн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих MV-015077 тусгай зөвшөөрөлтэй “Хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөө эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2025 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Г.ЭНХМӨНХ

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ**

**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС**

**2024 оны 10-р сарын 03** **Улаанбаатар хот**

**Дугаар 2024/ОА-50**

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:*** "ТАЛСТ ДИСКОВЕРИ" ХХК, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Ривер гарден, 405, 803 тоот.
***Холбоо барих утас, И-мэйл хаяг:*** 99966101.
***Төслийн нэр:*** Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих MV-015077 тусгай зөвшөөрөлтэй "Хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах" төсөл.
***Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр,байршил:*** Дорноговь аймгийн Даланжаргалан сум.
***Санал:*** Сумын Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 01/455 дугаар албан бичиг,АМГТГ-ын 2020.08.07-ний өдрийн Т/129 дугаар тушаал, И-Бизнес цахим системийн **О77-2409-000066** тоот хүсэлтийг үндэслэв.

| [redacted] | | | | | |
|---|---|---|---|---|---|
